

“БИДИСЕК” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА

Танилцуулгын эхний хэсэг

1. Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаархи мэдээлэл, судалгаа:

- БиДиСек” ХК нь хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж эхлээд 17 жил болж буй тус зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага.
- 2006 онд олон нийтэд өөрийн хувьцааг санал болгон арилжаалан хөрөнгийн зах зээл дээрээс 1 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлж үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллаж, өнгөрсөн жилүүдэд хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ сайн биелүүлж, 2007 оны хөрөнгийн зах зээлийн “Шилдэг хувьцаат компани”-аар тодорсон.
- Өнгөрөгч 2007 онд тус компанийн татварын дараах цэвэр ашиг 990 сая төгрөгт хүрч өмнөх оноос 20,9 дахин өссөн байгаа.
- Компани 2006 онд олон нийтэд хувьцаагаа гарган хөрөнгө татан төвлөрүүлснээс хойш үйл ажиллагааны ашгаас 2006 онд нэгж хувьцаанд 3 MNT, 2007 онд нэгж хувьцаанд 30 MNT-ийн ноогдол ашиг тарааж байна.

“БиДиСек” ХК – Тусгай Зөвшөөрлүүд

- 1996 оноос Брокер, дилер
- 2005 оноос Андеррайтинг
- 2006 оноос Нээлттэй Хувьцаат компани болсон
- 2007 оноос Хөрөнгө оруулалтын зөвлөх

Андеррайтерын үйл ажиллагаа

“БиДиСек” ХК нь Монголын хөрөнгийн зах зээлд андеррайтерын үйлчилгээг гүйцэтгэхдээ компанийн “Андеррайтерын үйлчилгээний дотоод журам”-ын дагуу төслүүдийг хүлээн авч журамд заасан тоон болон тоон бус шалгуур үзүүлэлтүүдийн дагуу төсөл хэрэгжүүлэгч компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан хамтран ажилладаг. Бид:

- ✓ 2005 онд нийт 6 төсөл хүлээн авч 1 компанийн бонд гаргаж олон нийтэд арилжаалсан.
- ✓ 2006 онд нийт 15 төсөл хүлээн авч 2 компанийн хувьцаа, 1 компанийн бонд гаргасан.


- ✓ 2007 онд нийт 23 төсөл хүлээн авч 3 компанийн хувьцаа, 1 компанийн бонд гаргаж мөн 4 компанид хувийн хөрөнгө оруулалт хийн ажиллаж байна.
- ✓ 2008 оны байдлаар нийт 16 төсөл хүлээн аваад байгаа бөгөөд эдгээрийн 2 компанигай нь хувьцаа гаргахаар ажиллаж байна.

"БиДиСек" ХК-ийн Андеррайтинг хийсэн хувьцаанууд

Компанийн нэр	Хувьцааны тоо	IPО зах зээлд арилжаалагдсан үнэ	Хаалтын ханш /2008.05.13/	Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө
Монгол шилтгээн	1`000`000	800	1`200	800`000`000
Женко Тур Бюро	70`000`000	100	245	8`500`000`000
Хай Би Ойл	4`000`000	100	350	400 000 000
	2`000`000	300	350	600`000`000
Монинжбар	10`000`000	100	250	1 000`000`000
Туул Сонгино Усны нөөц	13`200`000	1000	1`100	13`200`000`000

Харилцагчид


Харилцагчдын өсөлт



харилцагчдын тоо нэмэгдсэн. 2006-2007 онд "Женко Тур Бюро" ХК-ийн "50`000 бяцхан хувьцаа эзэмшигч хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлснээр нийт харилцагчдын тоо 140%-аар өссөн.

- ✓ Нийт харилцагчдын 45%-ийн УБ хотын харилцагчид, 17%-ийг Төв аймгийн үндсэн харилцагчид, 0,2%-ийг гадаад харилцагчид, 37,8%-ийг бусад аймгийн харилцагчид эзэлдэг.
- ✓ Монголын хөрөнгийн зах зээлд оролцдог гадаад харилцагчдын 80%, томоохон байгууллагуудын 60% нь "БиДиСек" ХК-аар үйлчлүүлж байна.

Зах зээлийн үнэлгээ



Хувьцааны арилжааны хэмжээ

